



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/294

Улаанбаатар хот

Г  
Нийслэлийн хүн амд мэс заслын тусlamж,  
үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын  
үйлчлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.13 дахь, 12 дугаар зүйлийн 12.1.14 дэх заалт, нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хүн амд мэс заслын тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээний хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Ачтан, Номун, Грандмед, Мөнгөнгүүр, Натул эмнэлгийн дарга нарт үүрэг болгох нь:
  - 2.1. Тушаалын хавсралтад заагдсан хуваарийн дагуу 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн холбогдох харьяаллын хүн амд мэс заслын тусlamж, үйлчилгээг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, журам, зааврыг мөрдөн үзүүлэх,
  - 2.2. Иргэдэд мэс заслын тусlamж үйлчилгээг хугацаа алдалгүй шуурхай үзүүлж, гомдол, чирэгдэлгүйгээр ажиллах,
3. Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т үүрэг болгох нь:
  - 3.1. Мэс заслын тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг тогтмол хугацаанд дүгнэж, үр дүнг тооцон, хяналт тавьж ажиллах,
  - 3.2. Тодорхой шалтгаанаар эрүүл мэндийн даатгалын байгууллагаас санхүүжилт зогссон тохиолдолд тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын саналыг боловсруулан, шуурхай шийдвэрлүүлэх,
4. Мэс заслын тусlamж, үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгох, 2018 оны төсөвт нэмэгдүүлэн шийдвэрлэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Б.Төмөртогоо/-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

080933

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/279 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ





ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ОХООСАРЫН 27-НЫ ӨДРИЙН  
ДУГААРТУШААЛЫН ХАВСРАЛТ

*... дугаартаалын хавсралт*

МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭНИЙ ХУВААРЬ

Тусламж, Үйлчилгээний терөл	Баянгол дүүрэг	Баянзурх дүүрэг	Багануур дүүрэг	Багахангай дүүрэг	Налайх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг
Мэс заслын тусламж, Үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	“Ачтан” эмнэлэг /1- 23 дугаар хороо/ хороо/	Багануур эрүүл мэндийн нэгдэл	Цэргийн төв эмнэлэг	Багануур эрүүл мэндийн нэгдэл	Налайх эрүүл мэндийн нэгдэл	“Номуун” эмнэлэг /1-3, 7-11, 18, 20, 22-25, 28 дугаар хороо/ хороо/	“Мөнгөн гүүр” эмнэлэг /12-17, 21, 29-31 дугаар хороо/ хороо/	“Грандмед” эмнэлэг	“Номуун” эмнэлэг
Лавлагaa	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг	Улсын нэгдүүээр төв эмнэлэг